



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын 17 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/063/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: [Usukhbayarts@audit.gov.mn](mailto:Usukhbayarts@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: [shijirboldg@audit.gov.mn](mailto:shijirboldg@audit.gov.mn)

Аудитор: О.Чойдорж

Утас: 70533552 Цахим хаяг: [choidorjo@audit.gov.mn](mailto:choidorjo@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага.....	10
3.3 Зөвлөмж.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	12

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 197

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-  
ОВОО СУМЫН 17 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ш.ГЭРЭЛМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын 17 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын сайдын шийдвэрээр албан хаагчдад 5.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг сар бүр тооцож олгосон байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 794,766.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 775,045.7 мянган төгрөг зарцуулсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 52,903.5 мянган төгрөг, Говийн оюу хөгжлийн дэмжих сангаас 3,715.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050335

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	54,073,844.20	28,187,290.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		54,073,844.20	28,187,290.07
3121	Төгрөг		54,073,844.20	28,187,290.07
31211	Төрийн сангийн харилцах		54,073,844.20	28,187,290.07
33	АВЛАГА	5	416,031.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	6	49,199,770.00	63,535,752.00
351	Түүхий эд материал		24,689,600.00	24,689,600.00
35110	Тусгай зориулалттай материал		24,489,600.00	24,489,600.00
35130	Эм боох материал		200,000.00	200,000.00
354	Хангамжийн материал		24,510,170.00	38,846,152.00
35410	Бичиг хэргийн материал		3,265,700.00	5,060,700.00
35420	Аж ахуйн материал		14,181,470.00	24,895,670.00
35460	Хүнсний материал		2,748,300.00	4,575,082.00
35470	Бусад хангамжийн материал		4,314,700.00	4,314,700.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		103,689,645.20	91,723,042.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	497,803,667.76	477,074,283.78
392	Биет хөрөнгө		494,203,147.76	473,473,763.78
39201	Барилга, байгууламж, орон сууц		<u>597,495,693.82</u>	<u>597,495,693.82</u>
39202	Хуримтлагдсан элэгдэл		- 213,201,553.71	-257,352,582.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		73,674,921.28	76,074,921.28
39206	Хуримтлагдсан элэгдэл		- 20,239,789.03	- 37,025,522.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		59,694,064.00	83,072,564.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		- 11,388,466.60	-27,059,587.90
39214	Бусад үндсэн хөрөнгө		3,700,000.00	34,540,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл			- 740,000.04
393	Ном		4,468,278.00	4,468,278.00
39301	Биет бус хөрөнгө		3,600,520.00	3,600,520.00
39302	Хуримтлагдсан элэгдэл			
39303	Бусад биет бус хөрөнгө		3,600,520.00	3,600,520.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		497,803,667.76	477,074,283.78
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		601,493,312.96	568,797,325.85
41	Богино хугацаат өр төлбөр	9		171,513.00
413	Өглөг			171,513.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг			171,513.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР			171,513.00
51	Засгийн газрын хувь оролцоо		601,493,312.96	568,625,812.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		442,994,363.07	442,994,363.07
51101	Өмч: - төрийн		442,994,363.07	442,994,363.07
512	Хуримтлагдсан үр дүн		76,041,634.20	43,174,134.09
51210	Өмнөх үеийн үр дүн		<u>76,041,634.20</u>	<u>76,041,634.20</u>
51220	Тайлант үеийн үр дүн			<u>-32,867,500.11</u>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		82,457,315.69	82,457,315.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		601,493,312.96	568,625,812.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		601,493,312.96	568,797,325.85

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		455,733,600.00	620,351,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		403,681,700.00	565,727,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		403,681,700.00	565,727,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		52,051,900.00	54,624,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		52,051,900.00	54,624,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		180,011,825.28	210,674,283.00
120	Нийтлэг татварын бус орлого		180,011,825.28	210,674,283.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		124,959,990.00	140,884,179.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		114,198,740.00	140,884,179.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10,761,250.00	
120009	Бусад орлого			385,104.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		51,201,835.28	56,618,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,850,000.00	12,786,500.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	635,745,425.28	831,026,083.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		637,288,261.54	863,893,583.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		617,446,221.54	851,431,678.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		401,980,361.00	602,963,380.13
210101	Үндсэн цалин		274,406,238.00	354,835,550.37
210102	Нэмэгдэл		116,849,623.00	213,520,536.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт			1,730,000.00
210104	Урамшуулал		10,724,500.00	32,877,293.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		48,722,650.21	70,764,678.00
210201	Тэтгэврийн даатгал		36,420,570.21	49,402,800.00
210202	Тэтгэмжийн даатгал		3,182,080.00	5,663,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,450,000.00	2,281,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,450,000.00	2,281,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		6,220,000.00	11,135,078.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		39,174,860.00	39,162,095.00
210301	Гэрэл, цахилгаан		2,973,805.00	3,821,040.00
210302	Түлш, халаалт		27,621,055.00	27,621,055.00
210303	Цэвэр, бохир ус		8,580,000.00	7,720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		3,830,510.00	5,671,400.00
210401	Бичиг хэрэг		780,000.00	1,275,500.00
210402	Тээвэр, шатахуун		1,719,410.00	920,950.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс		706,100.00	3,474,950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		625,000.00	
2105	Нормативт зардал		47,319,630.00	45,812,741.00
210502	Хоол, хүнс		47,319,630.00	45,812,741.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,000,000.00	6,699,500.00
210604	Урсгал засвар		3,000,000.00	6,699,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		325,000.00	670,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		325,000.00	670,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал		73,093,210.33	79,687,883.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,636,713.00	1,847,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,749,850.00	493,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		67,706,647.33	77,347,883.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		19,842,040.00	12,461,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		16,400,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		16,400,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		3,442,040.00	12,461,905.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,442,040.00	12,461,905.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	637,288,261.54	863,893,583.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		-1,542,836.26	- 32,867,500.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		448,597.27	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		448,597.27	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-448,597.27	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		- 1,991,433.53	- 32,867,500.11

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	569,932,340.00	761,621,083.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,198,740.00	141,269,283.00
120	Нийтлэг татварын бус орлого	114,198,740.00	141,269,283.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	114,198,740.00	140,884,179.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,198,740.00	140,884,179.00
120009	Бусад орлого		385,104.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	455,733,600.00	620,351,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,681,700.00	565,727,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,681,700.00	565,727,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,051,900.00	54,624,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,051,900.00	54,624,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	574,061,950.21	787,507,637.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,061,950.21	787,507,637.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,219,910.21	775,045,732.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401,980,361.00	602,375,836.13
210101	Үндсэн цалин	274,406,238.00	354,419,519.37
210102	Нэмэгдэл	116,849,623.00	213,520,536.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,703,000.00
210104	Урамшуулал	10,724,500.00	32,705,780.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,722,650.21	70,764,678.00
210201	Тэтгэврийн даатгал	36,420,570.21	49,402,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,182,080.00	5,663,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,450,000.00	2,281,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,450,000.00	2,281,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,220,000.00	11,135,078.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,609,860.00	39,162,095.00
210301	Гэрэл, цахилгаан	2,973,805.00	3,821,040.00
210302	Түлш, халаалт	27,621,055.00	27,621,055.00

210303	Цэвэр, бохир ус	15,015.00	7,720,000.00
2105	Нормативт зардал	42,280,030.00	47,639,523.00
210502	Хоол, хүнс	42,280,030.00	47,639,523.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	325,000.00	670,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	670,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,302,009.00	11,433,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,805,509.00	7,875,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	2,496,500.00	3,558,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,842,040.00	12,461,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,400,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,400,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,442,040.00	12,461,905.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,442,040.00	12,461,905.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,129,610.21	-25,886,554.13
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	2,000,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.00	
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-2,000,000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-6,129,610.21	-25,886,554.13
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,468,168.41	54,073,844.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,073,844.20	28,187,290.07

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	442,994,363.07	82,457,315.69	78,033,067.73	603,484,746.49
20.. оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	442,994,363.07	82,457,315.69	76,041,634.20	601,493,312.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			-32,867,500.11	
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	442,994,363.07	82,457,315.69	43,174,134.09	568,625,812.85

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	620,736,904.00	607,889,895.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	566,112,904.00	565,727,800.00

131001	Улсын төсвөөс санхүүжих	566,112,904.00	565,727,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,624,000.00	42,162,095.00
132001	Орон нутгийн төсвөөс	54,624,000.00	42,162,095.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	140,884,179.00	140,884,179.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,884,179.00	140,884,179.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	761,621,083.00	749,159,178.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	856,646,400.00	775,045,732.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,646,400.00	775,045,732.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	643,665,500.00	602,375,836.13
210101	Үндсэн цалин	380,947,400.00	354,419,519.37
210102	Нэмэгдэл	253,966,100.00	213,520,536.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,730,000.00
210104	Урамшуулал	8,752,000.00	32,705,780.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,105,400.00	70,764,678.00
210201	Тэтгэврийн даатгал	54,358,600.00	49,402,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,436,700.00	5,663,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,218,400.00	2,281,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,218,400.00	2,281,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,873,300.00	11,135,078.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,879,800.00	39,162,095.00
210301	Гэрэл, цахилгаан	13,208,700.00	3,821,040.00
210302	Түлш, халаалт	37,091,100.00	27,621,055.00
210303	Цэвэр, бохир ус	8,580,000.00	7,720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	53,453,900.00	47,639,523.00
210502	Хоол, хүнс	53,453,900.00	47,639,523.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,080,000.00	670,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,080,000.00	670,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,461,800.00	11,433,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,902,800.00	7,875,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,559,000.00	3,558,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	856,646,400.00	775,045,732.13
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		54,073,844.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		28,187,290.07

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 98,815.3 мянган төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 98,815.3 мянган төгрөгийн 5 алдааг залруулж ажилласан. Үүнд:

- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маяг"-ийн дагуу бэлтгээгүй,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг /төлөвлөгөө/ тус тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнтэй /төлөвлөгөө/ тулган баталгаажуулахад 95,025.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайланд урсгал засварын өглөгийн 3,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хоол хүнсний зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 19.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 385.1 мянган төгрөгөөр дутуу, улсын төсвөөс санхүүжих дүнг 385.1 мянган төгрөгөөр илүү толилуулсан.

Аудитаар нийт 17,752.9 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс 233.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,454.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 14,065.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 233.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А35/А/10/9 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ын 3-д "Багш, ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана", 3.2-т "Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тайлант хугацаанд албан хаагчдад 2,694.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг нэмэгдэл хөлс тооцох хуудсаар баталгаажуулаагүй олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгон журам"-ын гуравдугаар бүлгийн 1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Илрүүлэлт 2. Тайланд хугацаанд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 760.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй санхүүжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шашны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:1** Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 13 нэр төрлийн 53 ширхэг 14,065.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөн хөрөнгүүдийг жагсаалтыг гаргаж цаашид хэрхэн шийдвэрлэх саналыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж ажиллах, зөвлөмж хүргүүлэх

#### 1. Цалин хөлстэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:1** Ээлжийн амралт олгох мэдэгдлийг багш, ажилтанд олгоогүй.

**Өгсөн зөвлөмж:** Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийг "Ээлжийн амралт олгох мэдэгдэл" маягтын дагуу албан хаагчдад олгон ажиллах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй	1	0.0			1	0.0	1	0.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг /төлөвлөгөө/ тус тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнтэй /төлөвлөгөө/ тулган баталгаажуулахад 95,025.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	95,025.3			1	95,025.3	1	95,025.3				
Өглөгийн тодруулга тайланд урсгал засварын өглөгийн 3,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	3,000.0			1	3,000.0	1	3,000.0				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хоол хүнсний зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 19.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	19.8			1	19.8	1	19.8				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 385.1 мянган төгрөгөөр дутуу, улсын төсвөөс санхүүжих дүнг 385.1 мянган төгрөгөөр илүү толилуулсан	1	770.2			1	770.2	1	770.2				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>98,815.3</b>			<b>5</b>	<b>98,815.3</b>	<b>5</b>	<b>98,815.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 233.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон	1	233.8	1	233.8								
Тайлант хугацаанд албан хаагчдад 2,694.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг нэмэгдэл хөлс тооцох хуудсаар баталгаажуулаагүй олгосон	1	2,694.1			1	2,694.1						
Тайланд хугацаанд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 760.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй санхүүжүүлсэн	1	760.0			1	760.0						
Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 13 нэр төрлийн 53 ширхэг 14,065.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна.	1	14,065.0					1	14,065.0				
Ээлжийн амралт олгох мэдэгдлийг багш, ажилтанд олгоогүй.	1	0					1	0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>17,752.9</b>	<b>1</b>	<b>233.8</b>	<b>2</b>	<b>3,454.1</b>	<b>2</b>	<b>14,065.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>ДҮН</b>								